



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл,
үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийн
бүрэлдэхүүнийг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2020 оны 217, 2023 оны 301, 442 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын төлөвлөгөөний биелэлтийг үнэлэх, хянаж баталгаажуулах, мэдээлэх, үүрэг бүхий үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Албан хаагчдын гүйцэтгэлийн эхний хагас жилийн үнэлгээг 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор, сүүлийн хагас жилийн үнэлгээг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор тус тус хянаж, баталгаажуулахыг Үнэлгээний баг (З.Буянт)-т үүрэг болгосугай.

3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн үнэлгээний 85-100 буюу "Маш сайн", 70-84 буюу "Хэвийн", 70 хүртэлх оноог "Хангалтгүй" үнэлгээний ангилалд тус тус хамруулан тооцохыг Үнэлгээний баг (З.Буянт)-т даалгасугай.

4. "Маш сайн" үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын эхний хагас жилийн үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 100 хүртэлх хувиар, сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшууллыг 100 хүртэлх хувиар, "Хэвийн" үнэлгээнд хамрагдсан албан хаагчдын эхний хагас жилийн үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 50 хүртэлх хувиар, сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшууллыг 50 хүртэлх хувиар тус тус тооцон олгохыг, "Хангалтгүй" үнэлгээнд хамрагдсан албан хаагчид урамшуулал олгохгүй байхыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (А.Азжаргал)-д тус тус даалгасугай.

5. Үнэлгээний үр дүнг байгууллагын дотоод мэдээллийн сүлжээгээр нээлттэй мэдээллэх, гарсан алдаа дутагдлыг арилгах, албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлэх санал, зөвлөмж боловсруулах, чадавхыг дээшлүүлэх арга хэмжээг дараагийн тайлант хугацааны байгууллагын төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхийг Үнэлгээний баг (З.Буянт)-т тус тус үүрэг болгосугай.

6. Үнэлгээний багийн дарга, гишүүд болон нарийн бичгийн дарга нь нууцын баталгаа гарган, мэдээллийн давуу байдлаа ашиглан албан хаагчдын үнэлгээний дүн баталгаажихаас өмнө үнэлгээний дүн болон үнэлгээний үйл явцтай холбоотой аливаа мэдээллийг задруулахгүй байхыг Үнэлгээний багийн гишүүдэд үүрэг болгосугай.


7. Энэ тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/94 дүгээр тушаалыг хүчингүйд болсонд тооцсугай.

ДАРГА

С.ЭНХБАЯР

1720010383

Засаг даргын Тамгын газрын даргын 20
оны 06 дугаар сарын 08 -ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт



Үнэлгээний багийн бүрэлдэхүүн

Үнэлгээний багийн дарга:

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
Захиргааны бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах
мэргэжилтэн

Нарийн бичиг:

Хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан
мэргэжилтэн